



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ОРА-2021/19/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Орхон аймаг

2021 он

Тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас:70359826

Цахим хаяг:orkhon@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас:70355805

Цахим хаяг:erdeneb@audit.gov.mn

Аудитор: Г.Даваасүрэн

Утас:70350757

Цахим хаяг:orgilmurung@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХАА	Хөдөө аж ахуй
БҮТЭЗ	Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлс
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	12
3. Аудитын тайлан	13
3.1. Ерөнхий зүйл	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	13
3.4. Материаллаг байдал	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	15
3.7. Шилэн дансны мэдээлэл	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.9. Аудитын илрүүлэлт	16
Залруулсан алдаа	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	16
Аудитын зөвлөмж	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	17
4. Менежментийн захидал	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

№ 21
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	152228879.47	187845388.77
33	АВЛАГА	0.00	4244876.36
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	4244876.36
35	БАРАА МАТЕРИАЛ	152228879.47	183600512.41
351	Түүхий эд материал	148323762.47	174779827.41
35110	Тусгай зориулалттай материал	21014797.00	22473616.00
35130	Эм боох материал	127308965.47	152306211.41
354	Хангамжийн материал	3905117.00	8820685.00
35410	Бичиг хэргийн материал	1152200.00	2350210.00
35420	Аж ахуйн материал	1632417.00	2410875.00
35430	Сэлбэг хэрэгсэл	970500.00	1949600.00
35440	Түлш, шатах тослох материал	150000.00	660000.00
35470	Бусад хангамжийн материал	0.00	1450000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	247226310.92	244661319.79
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	247226310.92	244661319.79
391	Газар		
392	Биет хөрөнгө	246529644.22	242684653.05
39203	Авто-тээврийн хэрэгсэл	100701698.30	147488298.30
39204	Хуримтлагдсан элэгдэл	-33047585.96	-52425672.81
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	476457614.93	488754515.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	-319658491.34	-364051777.84
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39217694.60	43537694.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17141286.31	-20618405.13
393	Биет бус хөрөнгө	696666.70	1976666.74
39301	Програм хангамж	880000.00	2380000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-183333.30	-403333.26
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	399455190.39	432506708.56
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	399455190.39	432506708.56
51	Засгийн газрын хувь оролцоо	399455190.39	432506708.56
512	Хуримтлагдсан үр дүн	399455190.39	432506708.56
51210	Өмнөх үеийн үр дүн	0.00	399455190.39
51220	Тайлант үеийн үр дүн	399455190.39	33051518.17
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	399455190.39	432506708.56

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	808933386.16	499018194.36
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	439605005.16	135859404.36
120	Нийтлэг татварын бус орлого	439605005.16	135859404.36
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	439605005.16	135859404.36
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4370000.00	7377250.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	120000.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	435115005.16	128482154.36
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	369328381.00	363158790.00

Орхон аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1310	Улсын төвлөрсөн төсвөөс	292371800.00	308793400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	292371800.00	308793400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	76956581.00	54365390.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	47637971.00	38068000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29318610.00	16297390.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	411222195.77	465966676.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	411222195.77	465966676.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	404174496.82	439137683.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	37425000.00	50575599.10
210101	Үндсэн цалин	36000000.00	39482000.00
210102	Нэмэгдэл	235000.00	8213600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1190000.00	2879999.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5212700.00	6827800.00
210201	Тэтгэврийн даатгал	3544600.00	4804800.00
210202	Тэтгэмжийн даатгал	417100.00	505700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	333600.00	404700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	83500.00	101100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	833900.00	1011500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21506094.75	40776689.50
210301	Гэрэл, цахилгаан	2041721.00	3254000.00
210302	Түлш, халаалт	1484968.50	1358493.50
210303	Цэвэр, бохир ус	992805.25	1192500.00
210304	Байрны түрээс	16986600.00	34971696.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12531733.00	19472903.00
210401	Бичиг хэрэг	2616680.00	2761070.00
210402	Тээвэр, шатахуун	7652200.00	7146000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	915470.00	1815656.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1347383.00	4234187.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	3515990.00
2105	Нормативт зардал	100812119.48	61418527.43
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	100812119.48	57827528.43
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	3590999.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26797632.00	268420.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	90000.00
210604	Урсгал засвар	26797632.00	178420.00
2107	Томилолт, зочны зардал	1866520.00	2144200.00
210702	Дотоод албан томилолт	1866520.00	2144200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	180100318.50	189966161.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	179897472.50	188950651.60
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	540000.00
210803	Даатгалын үйлчилгээ	78408.00	201110.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	102438.00	175399.50
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22000.00	99000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17922379.09	67687383.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	260000.00	218891.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17662379.09	67468492.13
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7047698.95	26828992.94

Орхон аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2132	Бусад урсгал шилжүүлэг	400000.00	1098000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400000.00	1098000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4683304.75	25730992.94
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4683304.75	25730992.94
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1964394.20	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1964394.20	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	397711190.39	33051518.17
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	397711190.39	33051518.17

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	374779098.00	370536040.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5450717.00	7377250.00
120	Нийтлэг татварын бус орлого	5450717.00	7377250.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4490000.00	7377250.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4370000.00	7377250.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	120000.00	0.00
120009	Бусад орлого	960717.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	369328381.00	363158790.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	292371800.00	308793400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	292371800.00	308793400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	76956581.00	54365390.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	47637971.00	38068000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29318610.00	16297390.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	341273398.00	362096139.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	341273398.00	362096139.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	333625699.05	335267146.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	41700000.00	50575599.10
210101	Үндсэн цалин	36000000.00	39482000.00
210102	Нэмэгдэл	2820000.00	8213600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2880000.00	2879999.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5212700.00	6827800.00
210201	Тэтгэврийн даатгал	3544600.00	4804800.00
210202	Тэтгэмжийн даатгал	417100.00	505700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	333600.00	404700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	83500.00	101100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	833900.00	1011500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21506094.75	40776689.50
210301	Гэрэл, цахилгаан	2041721.00	3254000.00
210302	Түлш, халаалт	1484968.50	1358493.50
210303	Цэвэр, бохир ус	992805.25	1192500.00

Орхон аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210304	Байрны түрээс	16986600.00	34971696.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10727110.00	10243126.00
210401	Бичиг хэрэг	2289180.00	2169470.00
210402	Тээвэр, шатахуун	6422200.00	5726000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1215470.00	1850656.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	800260.00	497000.00
2105	Нормативт зардал	15582571.00	13015198.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8883471.00	10499498.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6699100.00	2515700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26888432.00	7775569.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	565499.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	4350000.00
210604	Урсгал засвар	26888432.00	2860070.00
2107	Томилолт, зочны зардал	1866520.00	2144200.00
210702	Дотоод албан томилолт	1866520.00	2144200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	209181554.30	203908964.46
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	208978708.30	202893454.96
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	540000.00
210803	Даатгалын үйлчилгээ	78408.00	201110.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	102438.00	175399.50
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22000.00	99000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	960717.00	0.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	960717.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7647698.95	26828992.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	1000000.00	1098000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1000000.00	1098000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4683304.75	25730992.94
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4683304.75	25730992.94
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1964394.20	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1964394.20	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>33505700.00</u>	<u>8439901.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	33505700.00	8439901.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	33505700.00	8439901.00
2200	Дотоод эх үүсвэрээр	33505700.00	8439901.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	33505700.00	8439901.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-33505700.00</u>	<u>-8439901.00</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	399,455,190.39	0.00	399,455,190.39
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	399,455,190.39	0.00	399,455,190.39
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00		0.00	0.00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	399,455,190.39	0.00	399,455,190.39
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	399,455,190.39	0.00	399,455,190.39
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	399,455,190.39	0.00	399,455,190.39
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	33,051,518.17	0.00	33,051,518.17
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	432,506,708.56	0.00	432,506,708.56

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	294371800.00	292058495.25	311393400.00	290809513.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	294371800.00	292058495.25	311393400.00	290809513.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	293371800.00	291058495.25	309685900.00	289711513.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	41700000.00	41700000.00	50575600.00	50575599.10
210101	Үндсэн цалин	36000000.00	36000000.00	39482000.00	39482000.00
210102	Нэмэгдэл	2820000.00	2820000.00	8213600.00	8213600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2880000.00	2880000.00	2880000.00	2879999.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5212700.00	5212700.00	6827800.00	6827800.00
210201	Тэтгэврийн даатгал	3544600.00	3544600.00	4804800.00	4804800.00
210202	Тэтгэмжийн даатгал	417100.00	417100.00	505700.00	505700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	333600.00	333600.00	404700.00	404700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	83500.00	83500.00	101100.00	101100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	833900.00	833900.00	1011500.00	1011500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22582300.00	21506094.75	43528400.00	40776689.50
210301	Гэрэл, цахилгаан	1933600.00	2041721.00	3254000.00	3254000.00
210302	Түлш, халаалт	3154600.00	1484968.50	3255300.00	1358493.50
210303	Цэвэр, бохир ус	1192500.00	992805.25	1192500.00	1192500.00
210304	Байрны түрээс	16301600.00	16986600.00	35826600.00	34971696.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7930500.00	7894910.00	9040300.00	8843126.00
210401	Бичиг хэрэг	1904300.00	2169180.00	2169600.00	2169470.00
210402	Тээвэр, шатахуун	3524600.00	3710000.00	4332000.00	4326000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1605300.00	1215470.00	2001400.00	1850656.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	96000.00	0.00	78700.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	800300.00	800260.00	458600.00	497000.00
2105	Нормативт зардал	7796000.00	7762600.00	13015500.00	13015198.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3150000.00	3550000.00	10499500.00	10499498.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4646000.00	4212600.00	2516000.00	2515700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	52785100.00	52784832.00	14066500.00	14065570.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	22356400.00	25896400.00	6856400.00	6855500.00

Орхон аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	0.00	4350000.00	4350000.00
210604	Урсгал засвар	30428700.00	26888432.00	2860100.00	2860070.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	155365200.00	154197358.50	172631800.00	155607530.96
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	154334900.00	153994512.50	169886200.00	153092021.46
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	260000.00	0.00	540000.00	540000.00
210803	Даатгалын үйлчилгээ	482900.00	78408.00	325300.00	201110.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	175400.00	102438.00	175400.00	175399.50
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77000.00	22000.00	179000.00	99000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	0.00	1500000.00	1500000.00
210807	Газрын төлбөр	35000.00	0.00	25900.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1000000.00	1000000.00	1707500.00	1098000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1000000.00	1000000.00	1707500.00	1098000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1000000.0	1000000.0	1707500.00	1098000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	292371800.00	287688495.25	308793400.00	316201650.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	292371800.00	287688495.25	308793400.00	308824400.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	292371800.0	287688495.3	308793400.00	308824400.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	0.00	0.00	7377250.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих				7377250.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	19.00	16.00	19.00	16.00
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	15.0	11.0	15.00	11.00
620003	Үйлчлэх ажилтан	3.0	4.0	3.00	4.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	19.0	16.0	19.0	16.0
650001	Терийн захиргааны албан хаагч (ТЗ)	12.0	5.0	12.00	5.00
650009	Терийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7.0	11.0	7.00	11.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	67172215.80	53995533.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	67172215.80	53995533.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	67172215.80	53995533.50
2104	Хангамж, бараа материалын зардал	2712200.00	1400000.00
210402	Тээвэр, шатахуун	2,712,200.00	1,400,000.00
2107	Томилолт, зочны зардал	1866520.00	2144200.00
210702	Дотоод албан томилолт	1,866,520.00	2,144,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	62593495.80	50451333.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	62,593,495.80	50,451,333.50
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	369856.50
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		217888.50
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		151968.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	76956581.00	54365390.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	76956581.00	54365390.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	47,637,971.00	38,068,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,318,610.00	16,297,390.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Орхон аймгийн Мал эмнэлгийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Эрдэнэжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-аас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Даваасүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Орхон аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 25-ний өдрийн 14 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Орхон аймгийн Мал эмнэлгийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Хүнс Хөдөө аж ахуйн салбарын бодлого үйл ажиллагааг хэрэгжүүлэх, мал эмнэлгийн, малын эмийн сангийн үйлчилгээ эрхлэх, мал эмнэлэг ариун цэврийн магадлан шинжилгээ хийх.

ЗОРИЛГО: Хүн амын нийгмийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр мөрдөж байгаа дүрэм, журам, стандартыг нийтийн хэмжээнд мөрдүүлж салбарын хөгжлийн стратеги мэргэжлээ хөгжүүлэх бодлогын баримт баримт бичгийн хэрэгжилтийг хангах. Мал эмнэлгийн лабораторийн шинжилгээний чанар ажлын үр өгөөжийг сайжруулах замаар хүн амын хүнсний аюулгүй байдлыг ханган үйлчилгээний чанар хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд оршино.

ЗОРИЛТ: Гоц халдварт шимэгчтгэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тархвар зүйн судалгаанд тулгуурлан төлөвлөж хэрэгжүүлэн тандалт судалгааг явуулснаар гоц халдварт өвчингүй эрүүл тайван бүсийг баталгаажуулан зарлах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Орхон аймгийн Мал эмнэлгийн газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар нь 2020 онд шилэн дансанд хяналт хийсэн бөгөөд 3 зөрчил илрүүлэн зөвлөмж өгөн хяналт хийх хугацаандаа алдааг залруулсан байна. Орхон аймгийн Мал эмнэлгийн газар нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар улирал бүр тайлангаа илгээж байна.

Орхон аймгийн Мал эмнэлгийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны эхний хагас жилийн орлого үр дүнгийн тайлангийн нийт орлогын 223,037.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,223.0 мянган төгрөгөөр тооцсон ба гүйцэтгэлийн үе шатанд хувь хэмжээг өөрчлөөгүй бөгөөд нийт орлогын дүн жилийн дүн тул 499,018.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,990.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тогтоолоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Орхон аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 33,051.5 мянган төгрөгөөр буюу 8.3 хувиар өссөн байна. Нийт хөрөнгийн өсөлт нь тайлант онд дээд газраасаа ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис хэрэгсэл шилжүүлж авсантай холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	4,244.9	4,244.9
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	152,228.9	183,600.5	31,371.6
Үндсэн хөрөнгө	247,226.3	244,661.3	-2,565.0
Нийт хөрөнгө	399,455.2	432,506.7	33,051.5
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	399,455.2	432,506.7	33,051.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	399,455.2	432,506.7	33,051.5

Мөнгөн хөрөнгө данс үлдэгдэлгүй байна. Авлагын данс 4,244.9 мянган төгрөг болж нэмэгдсэн нь нийгмийн даатгалын шимтгэл болон хувь хүний орлогын албан татварын илүү тооцоолон шилжүүлсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 183,600.5 мянган төгрөг болж 31,371.6 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материал буюу ариутгал халдваргүйжүүлэлтийн бодисыг харьяа дээд газраас хүлээж авсантай холбоотой байна

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 244,661.3 мянган төгрөг болж 2,565.0 мянган төгрөгөөр буурсан байна. Үндсэн хөрөнгийн данс нь хандиваар болон үнэ төлбөргүй

шилжиж ирсэн 56,463.6 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн бөгөөд 67,468.5 мянган төгрөгийн элэгдэл тооцсон байна.

Өр төлбөр данс эхний болон эцсийн үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 432,506.7 мянган төгрөг болж 33,051.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Орхон аймгийн Мал эмнэлгийн газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 309,915.2 мянган төгрөгөөр буюу 38,3 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь 2019 онд шинээр байгуулагдаж үнэ төлбөргүй хөрөнгө орлого бүртгэсэн, энэ онд үнэ төлбөргүй хүлээн авсан орлого багассан нь шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 54,744.5 мянган төгрөгөөр буюу 13.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, нийгмийн даатгалын шимтгэл, байрны түрээсийн зардлууд байна. Энэ нь цалингийн нэмэгдэл болон мэл эмнэлгийн лаборатори шинээр ашиглалтад оруулахтай холбоотой байр нэмж түрээслэн зардлыг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 288,471.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 288,471.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 20,322.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 308,793.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70801 /мал эмнэлгийн лаборатори/, 70805 /мал эмнэлгийн газар/ хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 310,793.4 мянган төгрөг баталснаас, 308,793.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 2,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 308,824.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 7,377.3 мянган төгрөг, нийт 316,201.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 290,809.5 мянган төгрөгийг зарцуулж 25,730.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 290,809.5 мянган төгрөг буюу 91.9 хувьтай байгаа нь Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардал хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 38,068.0 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 16,297.4 мянга, нийт 54365.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс шатахуунд 1,400.0 мянга, дотоод албан томилолтод 2,144.2 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 50,451.3 мянга, нийт 53,995.5 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 217.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт, дээд шатны захирагчдаас олгосон санхүүжилтээс 152.0 мянган төгрөг тус тус төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллагын 2020 оны шилэн дансны хуулийн хэрэгжилтийг аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас шалгаж 3 төрлийн зөрчлийг илрүүлж, 3 зөвлөмж өгч шалгалтын хугацаанд зөрчлийг арилгасан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	3	0	3	0	0	0	100
Нийт дүн	3	0	3	0	0	0	100

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,856.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 235.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2,130.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага тогтоож, 490.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын нийт 456.4 мянган төгрөгийн 2 алдаа зөрчлийг аудитын явцад залрууллаа.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 2,365.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 235.7 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 2,130.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 албан шаардлага тогтоолоо. Үүнд:

1. Шатахууны урамшууллын орлого 235.7 мянган төгрөгийг орлогод бүртгэлгүй шууд зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:", 14.4.5-д "бүх орлого;" гэж заасан заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Төлбөрийн акт тогтоов.

2. Байгууллагын албан хэрэгцээнд ашигладаг Лада Нива лигэнд маркийн авто машины 100 км гүйлтэд зарцуулах тээвэр шатахууны зардлыг 15 литрээр тооцоолон нь 100 км-т явах нормоос хэтрүүлэн хэрэглэсэн, жолоочийн тооцооны хуудасны спидометрийн заалтын эхний эцсийн үлдэгдлийг хөтөлдөггүй, тээвэр шатахууны зардлыг хяналтгүйгээр зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалаар батлагдсан "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм" зэрэг заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Албан шаардлага хүргүүлэв.

3. Засгийн газраас тусгай зориулалтын дүрэмт хувцас өмсөх зөвшөөрөл бүхий байгууллагын жагсаалтад тус байгууллагын нэр байхгүй байхад иргэнтэй гэрээ байгуулан эмэгтэй хослол 10 ширхгийг худалдан авахад 2,010.0 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1-т "Төрийн албан хаагч хуульд заасны дагуу дүрэмт хувцас хэрэглэж болно", Засгийн газрын 2017 оны 286 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад заасан "Тусгай зориулалтын хувцас, хэрэглэлийн норм" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Албан шаардлага хүргүүлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 490.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндэсний итгэмжлэхийн төвийн даргын тушаалаар 3 мэргэжилтэн 2020 оны 11 дүгээр сарын 03-аас 2020 оны 11 дүгээр сарын 06-ны хооронд тус мал эмнэлгийн газарт лабораторийн итгэмжлэх хийсэн бөгөөд дээрх хугацаанд мал эмнэлгийн газраас албан томилолтын мөнгө гаргуулан авсан, баримтын бүрдүүлэлтийг шалгахад томилолтоор ажиллуулах удирдамжгүй, томилолтын тооцооны хуудас эх хувиараа байхгүй, байгууллагын удирдлагаар батлуулаагүй, томилолтоор ажилласан ажлын үр дүнгийн тайлан бичигдээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдах, холбогдох хууль тогтоомж зөрчих

1.3. Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Төсвийн захирагчийн 2021.02.19-ны өдрийн 26 тоот албан бичгээр хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

2. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Бараа материал зарлагадахдаа шаардах хуудсыг байгууллагын нярав өөрөө бичилт хийж зөвшөөрөл авдаг зөрчил илэрлээ.

Энэ нь Сангийн сайдын 347 тоот тушаалын “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар”-н 6-д “Материалын үнэ бүхий зүйлсийг байгууллагын үйлдвэрлэл, дотоод хэрэгцээнд зарцуулах шаардлага гарсан үед уг зүйлийг авч зарцуулах хүн “Шаардах хуудас”-ыг 1 хувь үйлдэж зөвшөөрөл авна. Эд хариуцагч шаардах хуудсыг үндэслэн материал, үнэ бүхий зүйлийг тавьж олгосны дараа агуулахын бүртгэлд бичилт хийж, тайлант хугацаанд нягтлан бодогчид хүргүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдах, холбогдох хууль тогтоомж зөрчих

2.3. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 347 тоот тушаалыг мөрдөж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Төсвийн захирагчийн 2021.02.19-ны өдрийн 26 тоот албан бичгээр хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

3. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 4, 12 дугаар саруудад албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдах, холбогдох хууль тогтоомж зөрчих

3.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийг зориулалт бусаар зарцуулахгүй байх, эдийн засгийн ангилал, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулахгүй байх.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Төсвийн захирагчийн 2021.02.19-ны өдрийн 26 тоот албан бичгээр хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН МЕНЕЖЕР:

Б.ЭРДЭНЭ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР:

Г.ДАВААСҮРЭН

Орхон аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 4, 12 дугаар саруудад албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдах, холбогдох хууль тогтоомж зөрчих

3.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийг зарцуулахдаа эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж байх.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Төсвийн захирагчийн 2021.02.19-ны өдрийн 26 тоот албан бичгээр хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:		
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:		Ц.НАРМАНДАХ
АУДИТЫН МЕНЕЖЕР:		Б.ЭРДЭНЭ
БЭЛТГЭСЭН:		
АУДИТОР:		Г.ДАВААСҮРЭН

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.02.16

Аудитын код: ОРА-2021/19/СТА-ТШЗ

Аудитын нэр: Орхон аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Шалгагдсан байгууллагын нэр: Орхон аймгийн Мал эмнэлгийн газар

(мянган төгрөг)

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шатахууны урамшууллын орлого 235.7 мянган төгрөгийг орлогод бүртгэлгүй шууд зарцуулсан байна.	235.7	Төлбөрийн акт тогтоох	Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч , Нягтлан бодох	П.Эрдэнэжаргал Э.Нямдорж
2	Байгууллагын албан хэрэгцээнд ашигладаг Лада Нива лигэнд маркийн авто машины 100 км гүйлтэд зарцуулах тээвэр шатахууны зардлыг 15 литрээр тооцоолон нь 100 км-т явах нормоос хэтрүүлэн хэрэглэсэн, жолоочийн тооцооны хуудасны спидометрийн заалтын эхний эцсийн үлдэгдлийг хөтөлдөггүй, тээвэр шатахууны зардлыг хяналтгүйгээр зарцуулсан байна.	120.0	Албан шаардлага өгөх	Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч , Нягтлан бодох	П.Эрдэнэжаргал Э.Нямдорж
3	Засгийн газраас тусгай зориулалтын дүрэмт хувцас өмсөх зөвшөөрөл бүхий байгууллагын жагсаалтад тус байгууллагын нэр байхгүй байхад иргэнтэй гэрээ байгуулан эмэгтэй хослол 10 ширхгийг худалдан авахад 2,010.0 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна.	2,010.0	Албан шаардлага өгөх	Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч , Нягтлан бодох	П.Эрдэнэжаргал Э.Нямдорж
4	Үндэсний итгэмжлэхийн төвийн даргын тушаалаар 3 мэргэжилтэн 2020 оны 11 дүгээр сарын 03-аас 2020 оны 11 дүгээр сарын 06-ны хооронд тус мал эмнэлгийн газарт лабораторийн итгэмжлэх хийсэн бөгөөд дээрх хугацаанд мал эмнэлгийн газраас албан томилолтын мөнгө гаргуулан авсан, баримтын бүрдүүлэлтийг шалгахад томилолтоор ажиллуулах удирдамжгүй, томилолтын тооцооны хуудас эх хувиараа байхгүй, байгууллагын удирдлагаар батлуулаагүй, томилолтоор	490.6	Зөвлөмж өгөх	Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч , Нягтлан бодох	П.Эрдэнэжаргал Э.Нямдорж

Орхон аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	ажилласан ажлын үр дүнгийн тайлан бичигдээгүй				
5	Бараа материал зарлагдахдаа шаардах хуудсыг байгууллагын нярав өөрөө бичилт хийж зөвшөөрөл авдаг байна.	-	Зөвлөмж өгөх	Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нягтлан бодох	П.Эрдэнэжаргал Э.Нямдорж
6	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 4, 12 дугаар саруудад албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгосон байна.	-	Зөвлөмж өгөх	Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нягтлан бодох	П.Эрдэнэжаргал Э.Нямдорж
ДҮН		2,856.3			

Бэлтгэсэн: Аудитор

Г.Даваасүрэн

Анхан шатанд хянасан: Аудитын менежер

Б.Эрдэнэ

Хоёр дахь шатанд хянасан: Дарга, тэргүүлэх аудитор

Ц.Нармандах

Орхон аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит					
	ажилласан ажлын үр дүнгийн тайлан бичигдээгүй				
5	Бараа материал зарлагдахдаа шаардах хуудсыг байгууллагын нярав өөрөө бичилт хийж зөвшөөрөл авдаг байна.	-	Зөвлөмж өгөх	Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нягтлан бодох	П.Эрдэнэжаргал Э.Нямдорж
6	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 4, 12 дугаар саруудад албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгосон байна.	-	Зөвлөмж өгөх	Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нягтлан бодох	П.Эрдэнэжаргал Э.Нямдорж
ДҮН		2,856.3			

Бэлтгэсэн: Аудитор

Г.Даваасүрэн

Анхан шатанд хянасан: Аудитын менежер

Б.Эрдэнэ

Хоёр дахь шатанд хянасан: Дарга, тэргүүлэх аудитор

Ц.Нармандах